



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/196

Мандалговь

Г Хүүхдийн эрхийн хууль зүйн  
хороо байгуулах тухай Т

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/51, А/69 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд зөв зохистой хүмүүжил олгох, хууль эрх зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дарга:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Гэр бүү, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн

Прокурорын газрын хяналтын прокурор Цагдаагийн газрын дарга

Боловсрол соёл, урлагийн газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Өмгөөлөгчдийн холбооны дарга


Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч "Оюуны гэгээ" ТББ-ын тэргүүн

Хоёр. Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн, мөрдэн шалгагдаж байгаа эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд хууль зүйн зөвлөгөө үйлчилгээ, туслалцаа үзүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг хүүхдийн эрхийн хууль зүйн хороо (Б.Түвшинбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн А/67 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488190514